



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХХ.23.ХЭЛЭЛЦСЭН нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хаалттай дэглэмийн байр (Баянзүрх дүүрэг, 21-р хороо, Ганц худгийн ам)-ыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байрт балансаас балансад шилжүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 2,570,970,558.60 (хоёр тэрбум таван зуун далан сая есөн зуун далан мянга таван зуун тавин найман төгрөг жаран мөнгө) төгрөгийн балансын үнэ, 53,561,886.66 (тавин гурван сая таван зуун жаран нэгэн мянга найман зуун наян зургаан төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хаалттай дэглэмийн байрыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байрт балансаас балансад шилжүүлэх асуудлыг дэмжээд, Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв." гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

